

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

**2008 оны 10 дугаар
сарын 22-ны өдөр**

дугаар 223

**Улаанбаатар
хот**

Журам батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2 дахь заалт, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Брокер, дилерийн үйл ажиллагааны журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Үнэт цаасны хорооны /хуучнаар/ 2003 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 33 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Харилцагчийн захиалгыг хүлээн авах, биелүүлэх тухай журам”, 2003 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 20 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны брокер, дилерийн компанид захиалгын гэрээ, захиалгын бүртгэл, дилерийн даалгаврын маягтыг хөтлөх заавар”-ыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Батлагдсан журамд нийцүүлэн 2009 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн дотор холбогдох дотоод журмаа шинэчлэн найруулж Хорооны Ажлын албаар хянуулахыг брокер, дилерийн компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, Гүйцэтгэх захирлуудад үүрэг болгосугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар /Х.Бум-Эрдэнэ/-т, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

БРОКЕР, ДИЛЕРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмаар брокер, дилерийн компанийн үйл ажиллагаа явуулах зарчим, хориглох үйл ажиллагаа, харилцагчтай байгуулах гэрээ, харилцагч үнэт цаас худалдах, худалдан авах талаар шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллээр хангах, харилцагчийн захиалга хүлээн авах, захиалга биелүүлэх, захиалгыг өөрчлөх, цуцлах, дуусгавар болгох, өөрийн хөрөнгөөр үнэт цаас худалдан авах, худалдах, брокер, дилерийн үйл ажиллагааны шимтгэл, харилцагчид мэдээлэл хүргэх, зар сурталчилгаа явуулах, дотоод хяналт хэрэгжүүлэх, бичиг баримт хадгалахтай холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1.2.1. “брокер, дилерийн компанийн ажилтан” гэж брокер, дилерийн компанийн харилцагчтай харилцдаг ажилтан болон түүний удирдах албан тушаалтныг;

1.2.2. “харилцагч” гэж брокер дилерийн компаниар үйлчлүүлдэг этгээдийг;

1.2.3. “мэргэжлийн институциональ хөрөнгө оруулагч” гэж хамтын хөрөнгө оруулалтын байгууллага, хөрөнгө оруулалтын сан, үнэт цаасны хөрөнгө оруулалтын менежментийн компани болон үнэт цаас худалдах худалдан авахад шаардлагатай эд хөрөнгийн болон мэргэжлийн боломжтой харилцагчийг;

1.2.4. “үнэт цаасыг худалдах, худалдан авах зах зээлийн захиалга” гэж үнэт цаасны тухайн өдрийн ханшийг харгалзахгүйгээр худалдах, худалдан авах захиалга тус бүрийн үнээр худалдаж, худалдан авч болох зарчмаар биелүүлэх захиалгыг;

1.2.5. “үнийн хязгаарлалттай захиалга” гэж үнэт цаас худалдах захиалгын хувьд үнийн доод хэмжээг, худалдан авах захиалгын хувьд үнийн дээд хэмжээг заасан захиалгыг;

1.2.6. “хойшлуулах болзлоор өгсөн захиалга” гэж бий болох эсэх нь мэдэгдэхгүй, эсхүл нэгэнт бий болсныг нь мэдээгүй байгаа үйл явдлаас шалтгаалан гэрээнд заасан эрх үүрэг нь үүсэхээр брокер, дилерийн компаниар тохиролцож өгсөн харилцагчийн захиалгыг;

1.2.7. “зар сурталчилгаа” гэж брокер, дилерийн компаниас үнэт цаас худалдах болон худалдан авахад зуучлах, бусад үйлчилгээг санал болгож, боломжит харилцагчийн анхаарлыг татах зорилгоор тодорхой бус этгээдүүдэд хандан олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон утас, интернет, цахим шуудан, хэвлэмэл хуудас зэрэг бусад хэлбэрээр түгээсэн мэдээллийг /Үүнд хуулийн дагуу брокер, дилерийн компаниас нийтэд мэдээлэх санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангийн хураангуй зэрэг мэдээлэл хамаарахгүй/;

1.2.8. ”брокерийн үйл ажиллагаа” гэж үнэт цаасны зах зээл дээр бусдын нэрийн өмнөөс үнэт цаасыг зуучлан худалдах, худалдан авах ажиллагааг;

1.2.9. ”дилерийн үйл ажиллагаа” гэж үнэт цаасны зах зээл дээр ашиг олох зорилгоор үнэт цаасыг өөрийн хөрөнгөөр худалдан авах, худалдах, арилжих ажиллагааг.

Хоёр. Брокер, дилерийн үйл ажиллагааны зарчим

2.1. Брокер, дилерийн компани нь хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах, үнэт цаасны зах зээлийн шударга байдлыг хангах үүднээс дараах зарчмыг баримталж ажиллана:

2.1.1. үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомжийг мөрдөж ажиллах;

- 2.1.2. брокер, дилерийн үйл ажиллагааг шударгаар явуулах, зохих ёсоор удирдах;
- 2.1.3. үйл ажиллагаа явуулахад шаардлагатай хүний болон техникийн нөөц, бололцоотой байх;
- 2.1.4. харилцагч үнэт цаас худалдах, худалдан авах шийдвэр гаргахад шаардлагатай үнэн зөв мэдээллээр хангах;
- 2.1.5. харилцагчтайгаа сонирхлын зөрчил үүсгэхгүй байх, үүссэн тохиолдолд харилцагчид мэдэгдэх.

Гурав. Хориглох үйл ажиллагаа

3.1. Брокер, дилерийн компанид дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

- 3.1.1. үнэт цаасны арилжаа болон үнэт цаасыг нийтэд худалдахаар санал болгох явцад нийтэд болон харилцагчид хуурамч мэдээлэл өгөх, төөрөгдүүлэх;
- 3.1.2. дотоод мэдээллийг ашиглан арилжаанд оролцох, нийтэд болон хөрөнгө оруулагчид хүргэх мэдээллийг нуун дарагдуулах, холбогдох этгээдэд өгөхөөс татгалзах;
- 3.1.3. үнэт цаасны ханшийг тодорхой түвшинд зохиомлоор тогтоон барих, өсгөх, бууруулах үйлдэл хийх;
- 3.1.4. үнэт цаасны арилжааны явцад өмчлөгч нь өөрчлөгдөөгүй буюу нэгдмэл сонирхолтой этгээдийн хооронд тухайн үнэт цаасны үнэ, ханшийг зохиомлоор өсгөх, бууруулах зорилгоор хуурамч гүйлгээ хийх;
- 3.1.5. тодорхой үнэт цаасны арилжаа идэвхтэй явагдаж байгаа мэтээр олон нийтийг төөрөгдүүлэх зорилгоор брокер, дилерийн болон нэгдмэл сонирхолтой бусад этгээдийн хооронд давхар гүйлгээ хийх;
- 3.1.6. үнэт цаасыг бүртгэх тухай Хорооны шийдвэр гарахаас өмнө үнэт цаасыг нийтэд санал болгох, сурталчлах;
- 3.1.7. харилцагчийн өгсөн буюу өгөх гэж буй нь баттай мэдэгдэж буй үнэт цаас худалдах, худалдан авах захиалга нь тухайн үнэт цаасны зах зээлийн үнэ ханшид нөлөөлөхгүйц байгаа тохиолдолд тухайн захиалгыг хүлээн авч буй брокер, дилерийн компани өөрийн дансаар тухайн үнэт цаасыг худалдах, эсхүл худалдан авах, эсхүл гуравдагч этгээдийг худалдах, эсхүл худалдан авахыг ятгах;
- 3.1.8. харилцагч үнийн хязгаарлалттай болон хойшлуулах болзлоор захиалга өгсөн тохиолдолд харилцагчийн захиалга биелэгдэхээс өмнө тухайн хязгаарласан үнээр буюу түүнээс илүү нөхцөл тогтоосон үнээр /худалдан авах захиалгын хувьд өндөр үнээр, худалдах захиалгын хувьд бага үнээр/ брокер, дилерийн компани тухайн үнэт цаасыг өөрийн болон нэгдмэл сонирхолтой этгээдийн дансаар худалдах, худалдан авах;
- 3.1.9. үйл ажиллагааныхаа явцад үнэт цаас гаргагчийн талаар олон нийтэд тараагдаагүй мэдээлэл олж авсан бол брокер, дилерийн компани өөрийн дансаар тухайн үнэт цаасыг худалдах, эсхүл худалдан авах, эсхүл гуравдагч этгээдийг худалдах, эсхүл худалдан авахыг ятгах;
- 3.1.10. мэргэжлийн институциональ хөрөнгө оруулагчийн хөрөнгө захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтан, тэдгээрийн гэр бүлийн хүнд бэлэг, унааны зардал өгөх, гуравдагч этгээдээс авсан үйлчилгээний төлбөрийг төлөх, үзвэр үзүүлэх зэрэг шууд болон шууд бусаар санхүүгийн хувьд ашигтай байдал бий болгох аливаа үйлдэл хийх, санал болгох;
- 3.1.11. өрсөлдөөнийг хязгаарлах зорилгоор үнэт цаасны үнэ, арилжаалах нөхцөл, авах шимтгэл болон бусад асуудлаар бусад брокер, дилерийн компанитай тохиролцох, эсхүл өөрчлүүлэх зорилгоор шууд болон шууд бус замаар нөлөөлөх;
- 3.1.12. үнэт цаасыг нийтэд санал болгон анх удаа гаргахад андеррайтерийн үүрэг гүйцэтгэж байгаа, эсхүл бусад санхүүгийн байгууллага баталгаа гаргаснаас бусад тохиолдолд

брокер, дилерийн компани өөрийн хяналтын багцыг эзэмшиж буй хувь нийлүүлэгчийнхээ гаргасан үнэт цаасыг худалдан авах;

3.1.13. баталгаа, батлан даалт гаргах, бусдын хүлээсэн үүргийн биелэлтийг хангах зорилгоор компанийн эд хөрөнгийг барьцаалуулах;

3.1.14. харилцагчийн өмчлөлд байгаа үнэт цаасны тоо хэмжээ, түүнтэй холбогдох нийтэд тараагдаагүй мэдээллийг мэдээлэх, өмчлөгчийн зөвшөөрөлгүйгээр сонирхогч этгээдэд уг үнэт цаасыг худалдан авахыг санал болгох.

3.2. Брокер, дилерийн компанийн хяналтын багцыг хуулийн этгээд худалдан авах үед уг хуулийн этгээдийн гаргасан үнэт цаасыг тэрхүү брокер, дилерийн компани нь эзэмшдэг бол энэхүү байдал бий болсон үеэс 2 сарын дотор уг үнэт цаасыг бусдад шилжүүлсэн байна.

3.3. Үнэт цаасыг бусдад шилжүүлээгүй тохиолдолд тусгай зөвшөөрлийг 3 сар хүртэлх хугацаагаар түдгэлзүүлэх бөгөөд уг хугацаанд асуудлыг шийдвэрлэж чадахгүй бол тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно.

Дөрөв. Харилцагчтай байгуулах гэрээ

4.1. Брокер, дилерийн компани нь харилцагчид үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах бусад холбогдох үйлчилгээг үзүүлэх зорилгоор данс нээхдээ стандарт нөхцөлөөр болон тусгай нөхцөлөөр гэрээ байгуулна.

4.2. Стандарт нөхцөл бүхий гэрээний маягтыг тухайн брокер, дилерийн компанийн Төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол Хувь нийлүүлэгчдийн хурал/, эсхүл гүйцэтгэх захирал баталсан байх бөгөөд стандарт нөхцөлийн аль нэг гол нөхцөлийг талууд тохиролцож өөрчилсөн бол түүнийг тусгай нөхцөлөөр байгуулсан гэрээ гэж үзнэ.

4.3. Гэрээний стандарт нөхцөлд дараах зүйлсийг тусгаж болохгүй:

4.3.1. Брокер, дилерийн компанийн хууль бус үйл ажиллагааны улмаас харилцагчид хохирол учруулснаас үүсэх хариуцлагыг хязгаарласан зохицуулалт;

4.3.2. Брокер, дилерийн компанийн хууль бус үйл ажиллагааны улмаас харилцагчид учирсан хохирлыг нөхөн төлөх төлбөрийн дээд хэмжээг заасан зохицуулалт;

4.3.3. Харилцагчийн хууль тогтоомж болон гэрээнд заасан эрхээ хэрэгжүүлэх, гэрээг цуцлах эрхийг хязгаарлах, эсхүл хэт давуу тал олгосон зохицуулалт;

4.3.4. Иргэний хуулийн 198.1 дэх заалтын дагуу үгийн шууд утгаар харилцагчид ойлгогдох боломжгүй, маргаан гарсан тохиолдолд өөрт ашигтайгаар хэд хэдэн утгаар тайлбарлах боломжтой заалт.

4.4. Харилцагчийн бизнесийн үйл ажиллагаанаас шалтгаалан тухайн харилцагчтай стандарт нөхцөлөөр гэрээ байгуулах боломжгүй бол тусгай нөхцөлөөр гэрээ байгуулах бөгөөд тусгай нөхцөлөөр байгуулсан гэрээ нь харилцагч, брокер, дилерийн компанийн гүйцэтгэх захирал гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

4.5. Гэрээ байгуулсны дараа тухайн харилцагчийн тухай дараах мэдээллийг харилцагчийн ерөнхий мэдээллийн бүртгэлд бүртгэж өөрчлөлт орох бүрт баяжуулж хөтөлнө:

4.5.1. харилцагч иргэн бол түүний овог, эцгийн нэр, өөрийн нэр, регистрийн дугаар, иргэний үнэмлэхийн дугаар, гадаадын иргэн бол гадаад паспортын дугаар, албан ёсны болон оршин суугаа хаяг, утасны дугаар;

4.5.2. харилцагч хуулийн этгээд бол хуулийн этгээдийн нэр, регистрын дугаар, хаяг, утасны дугаар, итгэмжлэлгүйгээр төлөөлөх этгээдийн овог, эцгийн нэр, өөрийн нэр, регистрийн дугаар, иргэний үнэмлэхийн дугаар, гадаадын иргэн бол гадаад паспортын дугаар;

4.5.3. брокер, дилерийн компаниас тогтоосон бусад мэдээлэл.

Тав. Харилцагч үнэт цаас худалдах, худалдан авах талаар шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллээр хангах

5.1. Брокер, дилерийн компани нь харилцагч үнэт цаас худалдах, худалдан авах талаар шийдвэр гаргахад шаардлагатай дараах мэдээллээр хангах үүргийг хүлээнэ:

5.1.1. Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаас гаргасан мэдээнд тусгагдсанаар үнэт цаасны сүүлийн зургаан сарын арилжааны идэвх, үнэ, ханш, арилжаатай холбоотой нийтэд мэдээлэхийг хууль тогтоомжоор хориглоогүй бусад мэдээ;

5.1.2. Үнэт цаас гаргагчийн хаяг, ерөнхий болон санхүүгийн байдлын талаарх мэдээлэл /Үүнд тухайн үнэт цаас гаргагчаас нийтэд мэдээлэхээр заасан санхүүгийн мэдээллүүд хамаарна/.

5.2. Брокер, дилерийн компани нь харилцагчийг зөвхөн мэдээллээр хангах үүрэг хүлээх бөгөөд үнэт цаас худалдан авах, худалдахтай холбоотой аливаа зөвлөгөө өгсөн тохиолдолд түүнийг тусгай зөвшөөрөлгүйгээр хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхэлсэн гэж үзэж холбогдох хуульд заасан хариуцлага хүлээлгэх ба брокер, дилерийн компани нь тухайн хөрөнгө оруулагчид учирсан хохирлыг барагдуулах үүргээс чөлөөлөгдөхгүй.

Зургаа. Харилцагчийн захиалга хүлээн авах

6.1. Брокер, дилерийн компани нь захиалга өгч буй этгээд дансанд буй эд хөрөнгийг хууль ёсоор захиран зарцуулах эрхтэй эсэхийг урьдчилан шалгаж, уг харилцагчид захиалгыг биелүүлэх үйл явц, ажиллагааг танилцуулсны үндсэнд захиалгыг хүлээн авна.

6.2. Захиалга өгөх этгээд нь зөвхөн тухайн дансанд буй үнэт цаасны хууль ёсны эзэмшигч буюу данс эзэмшигч, данс эзэмшигч нь хуулийн этгээд бол тухайн хуулийн этгээдийг төлөөлөх эрх бүхий албан тушаалтан, эсхүл тэдгээрийг хууль ёсоор болон гэрээний үндсэнд төлөөлөх этгээд байна.

6.3. Харилцагчийн захиалгыг хүлээн авсан брокер, дилерийн компани нь захиалгыг бичгээр, дуу хоолойны болон дүрст бичлэгээр баталгаажуулсан байна.

6.4. Талууд дараах нөхцөлүүдийг заавал тохирсон байна:

6.4.1. худалдах, худалдан авах үнэт цаасны нэр;

6.4.2. үнэт цаасны тоо ширхэг;

6.4.3. үнийн хязгаарлалттай захиалга бол уг үнэт цаасны үнэ, эсхүл үнэт цаасыг худалдах, худалдан авах зах зээлийн захиалга эсэх, үнэт цаас худалдан авах зах зээлийн захиалга бол мөнгөний дүн;

6.4.4. хойшлуулах болзлоор өгсөн захиалга бол уг болзол.

6.5. Дуу хоолойны болон дүрст бичлэг нь тухайн харилцагчийн захиалга өгсөн эсэх, захиалга өгсөн цаг хугацааг хангалттай нотолж чадахуйц түвшинд байна. Бичлэгийг компьютерийн санамжид файл хэлбэрээр хадгалах бөгөөд бичлэг хийх техник хэрэгсэл нь энэхүү шаардлагыг хангахуйц байна.

6.6. Захиалгыг утсаар, цахим шуудангаар /e-mail/ болон бусад хэлбэрээр авахад дуу болон дүрст бичлэгээр, цахим хэлбэрээр баталгаажуулах журмыг брокер, дилерийн компани дотооддоо тогтоож мөрдүүлнэ.

6.7. Брокер, дилерийн компани нь компьютер ашиглан электрон хэлбэрээр захиалга авахад тусгай програм хэрэглэх бөгөөд энэхүү програм нь дараах шаардлагыг хангасан байна:

6.7.1. харилцагч зөвхөн өөрийн сонгосон нууц нэр, нууц үгээр нэвтэрч захиалга өгөх боломжтой байх;

6.7.2. харилцагчийн нууц нэр, нууц үгийг тухайн харилцагчаас бусад этгээд /брокер, дилерийн компанийн ажилтныг оролцуулан/ мэдэх боломжгүй байхаар програмчлагдсан байх;

6.7.3. харилцагчийн захиалга нь түүний цахим гарын үсгээр баталгаажсан байх нөхцлийг хангах.

6.8. Компьютерийн програмын алдаанаас шалтгаалан харилцагчийн захиалгыг биелүүлээгүй нь гэрээ зөрчсөн гэж үзэх үндэслэл болно.

6.9. Бичгээр өгсөн захиалгын баримтыг компанийн гүйцэтгэх захирал, төлөөлөн удирдах зөвлөлийн баталсан маягтын дагуу 2 хувь үйлдэх бөгөөд харилцагч, брокер, дилерийн компани тус бүр 1 хувийг хадгална.

6.10. Бичгээр өгсөн захиалгын баримтад захиалга өгсөн харилцагчийн нэр, регистрийн дугаар, гадаадын иргэн бол гадаад паспортын дугаар, гарын үсэг, хуулийн этгээд бол хуулийн этгээдийн нэр, төлөөлөх эрх бүхий этгээдийн нэр, албан тушаал, хуулийн этгээдийн тэмдэг, брокер, дилерийн компанийн захиалга хүлээн авсан брокерийн нэр, гарын үсэг, гэрээ байгуулсан огноо, цаг минут заавал байх бөгөөд брокер, дилерийн компанийн харилцагчийн захиалгад тусгайлан хэрэглэгдэх тэмдэг дарж баталгаажуулсан байна. Эдгээрийн аль нэг нь байхгүй байгаа нь гэрээг хүчин төгөлдөр бус гэж үзэх үндэслэл болно.

6.11. Хойшлуулах болзлоор өгсөн захиалгыг заавал бичгээр авна.

6.12. Арилжааны үеэр харилцагч брокер, дилерийн компанид үнэт цаас худалдах, худалдан авах захиалга өгөхөд утсаар захиалга авах нөхцөл журмыг нэгэн адил баримтална. Арилжаа эрхлэх байгууллага гишүүн брокер, дилерийн компаниудыг шаардлага хангасан техник, тоног төхөөрөмжөөр хангах үүрэг хүлээж энэ талаар журам тогтоож мөрдүүлнэ.

6.13. Харилцагч тодорхой тооны үнэт цаасыг худалдахаар хэд хэдэн брокер, дилерийн компанид нэгэн зэрэг захиалга өгч болохгүй бөгөөд ийм тохиолдолд хамгийн эхэнд өгсөн захиалгыг хүчин төгөлдөр гэж үзнэ. Харилцагч нь бусад брокер, дилерийн компанид тухайн захиалгын дагуу төлөх байсан шимтгэлтэй тэнцүү хэмжээний мөнгөн хөрөнгийг төлөх үүрэгтэй байна.

6.14. Үнэт цаас худалдах захиалгын хүчин төгөлдөр байх хугацаа ажлын 78 хоног, худалдан авах захиалгын хүчин төгөлдөр байх хугацаа ажлын 26 хоног байна.

6.15. Брокер, дилерийн компани нь үнэт цаасны зах зээлийн хууль тогтоомж зөрчих нөхцөлтэй харилцагчийн захиалгыг хүлээн авахгүй.

Долоо. Захиалга биелүүлэх ажиллагаа

7.1. Харилцагчийн захиалгыг хүлээн авсан брокер, дилерийн компани нь захиалгыг хойшлуулах болзолтойгоос бусад тохиолдолд Улаанбаатар хотод дараа өдөр, орон нутагт 3 хоногт багтааж энэхүү журмын 1 дүгээр хавсралтаар батлагдсан маягтын дагуу үйлдсэн дилерийн даалгаварт үнэн зөв тусгуулж, дилерт шилжүүлснээр уг захиалгыг биелүүлэх үйл ажиллагаа эхэлнэ

7.2. Харилцагчийн захиалгыг бүртгэж дугаарлах ба үнэт цаасны захиалгын дугаарыг давхардуулахгүй. Брокер, дилерийн компанийн салбар бүрт тухайн салбарыг илэрхийлсэн код өгч захиалгыг дугаарлахдаа ашиглана.

7.3. Захиалгын бүртгэлийг бичгээр болон цахим хэлбэрээр хийх бөгөөд захиалгыг үнийн болон цаг хугацааны дарааллаар нэгтгэн дилерийн даалгаварт тусгаж арилжаа эхлэхээс 1 цагийн өмнө бэлэн болгоно. Дилерт шилжүүлсний дараа харицагч захиалгын гэрээнд өөрчлөлт оруулсан бол захиалгыг хүлээн авсан брокер нэн даруй дилерт мэдэгдэн зохих өөрчлөлтийг оруулна.

7.4. Үнэт цаас худалдах зах зээлийн захиалгыг тухайн үнэт цаасны эрэлтийн хэмжээгээр, худалдан авах зах зээлийн захиалгыг тухайн үнэт цаасны нийлүүлэлтийн хэмжээгээр биелүүлнэ.

7.5. Ижил нөхцөлтэй захиалгыг үнэт цаас худалдан авахад үнийн доод, худалдахад үнийн дээд хэмжээг үндэслэн, үнэ тэнцсэн тохиолдолд хугацааны дарааллаар тус тус биелүүлнэ.

7.6. Харилцагчийн хойшлуулах болзолтойгоор өгсөн захиалгын болзолд заасан нөхцөл байдал бий болж захиалгад заасан эрх үүрэг нь үүссэний дараа брокер, дилерийн компани нь түүнийг дилерийн даалгаварт тусгаж биелүүлэх ажиллагааг эхлүүлнэ. Ийнхүү биелүүлэх ажиллагааг эхлүүлэх хүртэл брокер, дилерийн компани нь хойшлуулах болзолтойгоор өгсөн захиалгыг бүртгэж, болзолд заасан нөхцөл байдал бий болсон эсэхэд байнга хяналт тавьж байна.

7.8. Захиалгыг биелүүлэх явцад харилцагч болон брокер, дилерийн компани, тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээдийн хооронд сонирхлын зөрчил үүссэн бол энэ талаар харилцагчид нэн даруй мэдэгдэнэ.

Найм. Захиалгыг өөрчлөх, цуцлах, дуусгавар болгох

8.1. Харилцагч өөрийн захиалгыг тухайн үнэт цаасны арилжааны явцад өөрчилж, цуцалж болно.

8.2. Дараах тохиолдолд захиалгад өөрчлөлт оруулна:

8.2.1. харилцагч үнэт цаасны арилжааны явцад нэг буюу түүнээс дээш өдрийн туршид захиалга биелүүлэхгүй байхаар мэдэгдсэн;

8.2.2. харилцагч үнэт цаасны худалдах буюу худалдан авах үнэ /зах зээлийн болон үнийн хязгаарлалттай захиалгад нэгэн адил хамаарна/- ийг өөрчлөхөөр мэдэгдсэн;

8.2.3. харилцагч худалдах, худалдан авах үнэт цаасны тоо ширхэгт өөрчлөлт оруулахаар мэдэгдсэн.

8.3. Захиалгад өөрчлөлт оруулахад түүний хүчин төгөлдөр байх хугацаа өөрчлөгдөхгүй.

8.4. Харилцагч захиалгыг биелүүлэх явцад захиалгыг цуцлахыг хүсвэл энэ тухай брокер, дилерийн компанид мэдэгдэх ба холбогдох брокер нь энэ талаар дилерийн даалгаварт тэмдэглэл хийлгэнэ.

8.5. Харилцагч нь захиалгаа өөрчлөх, цуцлахдаа захиалга өгсөн арга хэлбэрээр, эсхүл брокер, дилерийн компанийн хүлээн зөвшөөрсөн бусад захиалга өгөх арга хэлбэрээр өөрчилж, цуцална.

8.6. Захиалга нь дараах тохиолдолд дуусгавар болно:

8.6.1. захиалгыг бүрэн биелүүлсэн;

8.6.2. зах зээлийн захиалгын хувьд үнэт цаасыг худалдан авахаар гэрээнд заасан мөнгөний хэмжээнд хүрсэн, дансанд байршуулсан мөнгө дууссан;

8.6.3. Захиалгын гэрээний үйлчлэх хугацаа дууссан;

8.6.4. Харилцагч үнэт цаасны 5 удаагийн арилжааны явцад өөрийн захиалгын гэрээг биелүүлэхгүй байхыг хүссэн тохиолдолд үнэт цаасны арилжаанд оролцохоос татгалзсан сүүлчийн өдрөөр тасалбар болгон.

8.7. Брокер, дилерийн компани нь арилжаанд тогтмол оролцдог харилцагчийн дансаар хийгдэх гүйлгээ үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомжийг зөрчиж буй эсэхэд байнга хяналт тавих бөгөөд хяналт тавих арга, хугацаа, хяналтын тайланг хэрхэн хадгалах талаар дотоод журмаараа зохицуулна.

8.8. Харилцагч үнэт цаасны зах зээлийн тухай хууль, тогтоомжийг зөрчсөнийг илрүүлбэл ийнхүү илрүүлснээс хойш ажлын 1 хоногийн дотор Хороонд мэдэгдэнэ.

Ес. Компанийн хөрөнгөөр үнэт цаас худалдах, худалдан авах

9.1. Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх захирал, компанийн дүрэмд заасан бусад эрх бүхий этгээдийн шийдвэрээр брокер, дилерийн компани нь өөрийн хөрөнгөөр үнэт цаас худалдах, худалдан авах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

9.2. Удирдлагын шийдвэрийг үндэслэн энэхүү журмын 2 дугаар хавсралтаар батлагдсан маягтын дагуу үйлдсэн “компанийн хөрөнгөөр үнэт цаас худалдах, худалдан авах дилерийн

даалгавар”-аар дилер арилжаанд оролцох бөгөөд арилжааны явцад үнэт цаас худалдах, худалдан авах шийдвэрийг гаргах эрхийг Төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувь нийлүүлэгчдийн хурал/- өөс дилерт олгож болно.

9.3. Дилер энэ журмын 9.2-т заасан шийдвэрийг гаргасан бол энэ тухай дилерийн даалгаварт тухай бүр тэмдэглэн, удирдлагуудад танилцуулж байна.

9.4. Үнэт цаасыг худалдах, худалдан авахдаа брокер, дилерийн компани нь харилцагчийн захиалгыг бүрэн биелүүлсний дараа өөрийн болон нэгдмэл сонирхолтой этгээдийн захиалгыг биелүүлнэ.

Арав. Брокер, дилерийн үйл ажиллагааны шимтгэл

10.1. Брокер, дилерийн компани нь үзүүлсэн үйлчилгээндээ шимтгэл авах бөгөөд шимтгэл тооцох аргачлал, журмыг дотоод журмаараа тогтоож мөрдөх бөгөөд энэ нь Санхүүгийн зохицуулах хорооны холбогдох журам зааварт нийцсэн байна.

10.2. Шимтгэлийг тогтоохдоо үзүүлсэн үйлчилгээний үнийн дүн, бусад зүйлийг харгалзан ижил үнийн дүнтэй захиалга ижил шимтгэлтэй байхаар компанийн дотоод журмаар шатлан тогтоох бөгөөд тусгай нөхцөлөөр гэрээ байгуулсан харилцагчийн хувьд шимтгэлийг өөрөөр тогтоож болохоор зохицуулж болно.

Арван нэг. Харилцагчид мэдээлэл хүргэх

11.1. Харилцагчтай гэрээ байгуулахын өмнө брокер, дилерийн компани нь үнэт цаасны зах зээлийн тухай ерөнхий ойлголт өгөх зорилгоор дараах мэдээллийг заавал танилцуулж гарын үсэг зуруулсан байна:

11.1.1. Хэлцэл хийгддэг буюу арилжаа явагддаг үйл явц, механизм;

11.1.2. Үнэт цаас худалдах, худалдан авахад хүлээж болох эрсдэл;

11.2. Брокер, дилерийн компани нь харилцагчийн өгсөн захиалга биелэгдэхэд түүнд үнэт цаасны нэр, код, хэлцэл хийгдсэн өдөр, үнэ, хэмжээ, шимтгэлийн хэмжээ, татварын талаарх мэдээллийг харилцагчид түүнтэй байгуулсан гэрээнд заасан цахим шуудан, утас, факс, бусад боломжит харилцаа холбооны хэрэгслээр нэн даруй мэдэгдэнэ:

11.3. Сар бүрийн эцэст брокер, дилерийн компани нь харилцагчийн дансны хуулгыг цахим шуудангаар явуулах буюу эсхүл харилцагч нууц үгийн тусламжтайгаар брокер, дилерийн компанийн сайтад нэвтрэн орж өөрийн дансыг байнга шалгаж байх боломжоор хангана.

11.4. Брокер, дилерийн компани нь харилцагчийн шаардсанаар дараах бичиг баримт болон мэдээллийг өгөх үүрэгтэй:

11.4.1. Тухайн компанийн үнэт цаасны зах зээл дээр мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл болон улсын бүртгэлийн гэрчилгээтэй холбогдсон бичиг баримт;

11.4.2. Өөрийн хөрөнгийн болон өр, зээл, санхүүгийн байдлын талаархи мэдээлэл;

11.4.3. Ажилтан нь мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотойгоор арга хэмжээ авагдсан, хариуцлага хүлээсэн тухай мэдээлэл.

Арван хоёр. Зар сурталчилгаа

12.1. Брокер, дилерийн компани нь үнэт цаас худалдах болон худалдан авахад зуучлах, бусад холбогдох үйлчилгээг санал болгож, нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон утас, интернет, цахим шуудан, хэвлэмэл хуудас зэрэг бусад хэлбэрээр зар сурталчилгаа явуулж болно.

12.2. Зар сурталчилгаа нь бодит байдалд нийцсэн байх бөгөөд төөрөгдүүлсэн, үндэслэлгүй мэдээлэл агуулаагүй байна.

12.3. Брокер, дилерийн компани нь үнэт цаасны зах зээлийн нөхцөл байдал, үнэт цаасаар хийх хөрөнгө оруулалтын талаарх зар сурталчилгаанаас бусад байдлаар нийтэд мэдээлэл хүргэхдээ буруу ойлголт төрүүлэхгүй, төөрөгдүүлэхгүй байх үүднээс мэдээлэл хүрэх этгээдүүдийн ерөнхий мэдлэг, ойлголтыг харгалзна.

12.4. Брокер, дилерийн компаниас нийтэд мэдээлэл хүргэх, зар сурталчилгаа явуулах стандартыг брокер дилерийн компаниудын гишүүнчлэл бүхий төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоо тогтоох бөгөөд энэхүү стандартыг гишүүн нь мөрдөх үүрэгтэй.

12.5. Брокер, дилерийн компани нь гуравдагч этгээдээс авсан аливаа мэдээллийг үнэт цаас худалдах, худалдан авахыг санал болгох, нийтэд мэдээлэл хүргэх үйл ажиллагаа, зар сурталчилгаа явуулахдаа ашиглах бол түүнийг үндэслэлтэй эсэхийг шалгасны үндсэн дээр иш татаж ашиглана.

12.6. Иш таталгүйгээр ашигласан мэдээлэл нь бодит байдалд нийцээгүй байсны улмаас аливаа этгээдэд учирсан хохирлыг брокер, дилерийн компани хариуцна.

Арван гурав. Дотоод хяналт

13.1. Брокер, дилерийн компани нь үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам болон энэхүү журамд заасны дагуу дотоод хяналтын үйл ажиллагааг зохицуулах журамтай байх ба дотоод хяналтын үйл ажиллагаатай холбоотойгоор Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага, дотоод хяналтын ажилтны үүрэг, хариуцлагыг зааглан тодорхой болгох үүрэгтэй.

13.2. Дотоод хяналт нь брокер, дилерийн компанийн нягтлан бодох бүртгэл болон эрсдлийн удирдлагын хяналтыг бүрэн хамаарч чадахуйц байх бөгөөд үйл ажиллагааны үе шат бүрт хяналт тавьж болохуйцаар зохион байгуулсан байна.

13.3. Дотоод хяналтыг тогтмол болон гэнэтийн хяналт шалгалтаар хэрэгжүүлэх бөгөөд дотоод хяналтын ажилтан буюу дотоод хяналтын баг нь шалгалт бүрийн дараа тайлан, дүгнэлт гаргаж гүйцэтгэх захиралд тайлагнана.

13.4. Энэ журмын 13.3-т заасан хяналт шалгалтыг хэрэгжүүлэх явцад ажилтны Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, тогтоомж зөрчсөн нь тогтоогдвол брокер, дилерийн компани нь түүнийг албан тушаал эрхлэхийг яаралтай түдгэлзүүлэн Хороонд зөрчлийн талаар нэн даруй мэдэгдэнэ. Ийнхүү мэдэгдэх үүргээ биелүүлээгүй бол тухайн зөрчлийг брокер, дилерийн компани гаргасанд тооцно.

13.5. Брокер, дилерийн компани нь ерөнхий захиргаа болон салбар, төлөөлөгчийн газар бүрт, эсхүл хэд хэдэн салбарт өөрийн ажиллагсдын үйл ажиллагаа хууль, тогтоомжид нийцэж байгаа эсэхэд хяналт тавих ажилтанг томилж ажиллуулна.

13.6. Дотоод хяналтын ажилтан нь үр нөлөө бүхий, шударга хяналтыг хэрэгжүүлж чадахуйц мэдлэг, дадал, туршлагатай байх ба брокер, дилерийн компани нь түүний хяналтаа хэрэгжүүлэхэд шаардлагатай бүхий л нөхцөл бололцоогоор хангана.

13.7. Дотоод хяналтын ажилтан нь компанийн бүх төрлийн бичиг баримт, бүртгэлийг шалгах, хяналтаа хэрэгжүүлэхэд шаардлагатай хуралд оролцох, хөндлөнгийн аудитор, хянан шалгах зөвлөлд мэдээлэл өгөх эрхтэй байна.

Арван дөрөв. Бичиг баримтыг хадгалах

14.1. Брокер, дилерийн компани нь Компанийн тухайн хуулийн 95 дугаар зүйлд зааснаас гадна дараах бичиг баримтыг 5 жил /аливаа үүрэг үүсгэсэн баримт бичиг, тухайлбал гэрээ, шүүхийн шийдвэр, төрийн захиргааны байгууллагын шийдвэрийг тухайн үүрэг дууссанаас хойш/ хадгалах үүрэгтэй:

14.1.1. Брокер, дилерийн үйл ажиллагаатай холбоотой бичиг баримт. Үүнд:
а/ Харилцагчтай байгуулсан данс нээх гэрээ, бусад холбогдох гэрээ;
б/ Харилцагчийн ерөнхий мэдээллийн бүртгэл;
в/ Үнэт цаас худалдах, худалдан авах харилцагчийн захиалгатай холбоотой бичиг баримт, дуу хоолойны болон дүрст бичлэг;
г/ Харилцагчийн дансны мөнгө хөрөнгийн гүйлгээтэй холбоотой баримтууд;
д/ Харилцагчийн дансны шилжилт хөдөлгөөний бүртгэл, хэлцлийн мэдээлэл /үнэт цаасны нэр, төрөл, хэлцлийн огноо, үнэ, шимтгэлийн хэмжээ, татварын хэмжээ/;
е/ Телевиз, радиогоор явуулсан зар сурталчилгааны агуулга, текст, бусад зар сурталчилгааны хуулбар, тэдгээрийн огноо, давтамжийн талаарх мэдээлэл.

14.1.2. Санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой бичиг баримт. Үүнд:
а/ Нягтлан болох бүртгэлийн тухай хууль тогтоомж, Хорооноос тогтоосон журмын дагуу гаргасан тайлан, тэнцэл, тайлангийн нэмэлт тодруулга;
б/ Компанийн холбогдох этгээд болон нэгдмэл сонирхолтой этгээдийн бүртгэл;
в/ Өөрийн данс дахь үнэт цаас, мөнгөн хөрөнгө, тэдгээртэй холбоотой хэлцлийн бүртгэл;
г/ Холбогдох этгээдтэй хийсэн хэлцлүүдийн бүртгэл.

14.1.3. Дотоод хяналтын үйл ажиллагаатай холбоотой бичиг баримт. Үүнд:
а/ Дотоод хяналтын үйл ажиллагааны тайлан, дүгнэлт,
б/ Дотоод хяналтын тайлангийн үр дүнд хийгдсэн ажлуудын тайлан, холбогдох бичиг баримтууд.

14.1.4. Харилцагчийн гаргасан гомдол, түүний агуулга, шийдвэрлэсэн байдал, тусгай зөвшөөрлийн болон хуулийн этгээдийн улсын бүртгэлтэй холбоотой бичиг баримт, гэрээ хэлцэл зэрэг бусад бичиг баримтууд.

14.2. Энэхүү журмын 13.1-т заасан хугацаа өнгөрсний дараа болон компани татан буугдсаны дараа бичиг баримтыг архивт шилжүүлэх харилцааг холбогдох хууль тогтоомжоор зохицуулна.

14.3. Брокер, дилерийн компани нь Хороо болон түүний улсын байцаагчийн шаардсанаар аливаа бичиг баримтыг нэн даруй гаргаж өгөх үүрэгтэй бөгөөд архивт шилжүүлсэн бичиг баримтыг шаардсан тохиолдолд архиваас хуулбарлан авсан албан ёсны хуулбарыг өгнө.

Арван тав. Хариуцлага

15.1. Брокер, дилерийн компанийн ажилтны хууль зөрчсөн үйлдлийг брокер, дилерийн компанийн хууль зөрчсөн үйлдэл гэж үзэж брокер, дилерийн компанид хариуцлага ногдуулна.

15.2. Брокер, дилерийн компани нь өөрийн ажилтны хууль зөрчсөн үйлдэл тухайн компанийн үйл ажиллагаа, удирдлагын шийдвэрээс шалтгаалаагүй, тухайн үйлдлийн сэдэлд ямар нэг холбоогүй гэдгээ хангалттай нотолсон тохиолдолд зөрчил гаргасан ажилтан, албан тушаалтанд хариуцлага ногдуулна.

15.3. Энэ журмыг зөрчсөн этгээдэд Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасан хариуцлага ногдуулна.

15.4. Энэ журамд заасан хориглох үйл ажиллагааг явуулсан, журам зөрчсөн нь тогтоогдвол уг үйл ажиллагааг гардан гүйцэтгэсэн этгээдийн үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил, үйлчилгээ явуулах эрхийг хүчингүй болгож, брокер, дилерийн компанийн тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэн захиргааны хариуцлага хүлээлгэх бөгөөд цаашид захиргааны шийтгэлтэйд тооцогдох хугацаанд дахин зөрчил гаргасан тохиолдолд хүчингүй болгоно.

_____ **БРОКЕР, ДИЛЕРИЙН КОМПАНИЙН**

ХАРИЛЦАГЧИЙН ЗАХИАЛГЫН ДИЛЕРИЙН ДААЛГАВАР¹

20.. оны .. сарын ..-ний өдрийн арилжаанд

Худалдах захиалга

Захиалгын гэрээний дугаар	Захиалга өгсөн огноо, цаг минут	Үнэт цаасны нэр, төрөл /код/	Харилцагчийн дансны дугаар	Үнэт цаасны		Захиалгын төрөл, нөхцөл	Захиалгын биелэлт		Тэмдэглэл
				Тоо, ширхэг	Нэг- жийн үнэ ²		Тоо, ширх эг	Нэг- жийн үнэ	

Худалдан авах захиалга

Захиалгын гэрээний дугаар	Захиалга өгсөн огноо, цаг минут	Үнэт цаасны нэр, төрөл /код/	Харилцагчийн дансны дугаар	Үнэт цаасны		Захиалгын төрөл, нөхцөл	Захиалгын биелэлт		Тэмдэглэл
				Тоо, ширхэг	Нэг- жийн үнэ ³		Тоо, ширх эг	Нэг- жийн үнэ	

Захиалга нэгтгэсэн -----/гарын үсэг/

Захиалга хянасан-----/гарын үсэг/

Санхүүгийн зохицуулах хорооны

¹ Худалдах болон худалдан авах захиалгаар дилерийн даалгаврыг салган үйлдэж болно.

² Үнийн хязгаарлалттай захиалга бол уг үнэт цаасны нэгжийн үнэ, үнэт цаасыг худалдах зах зээлийн захиалга бол “Зах Зээлийн” гэсэн тэмдэглэгээ хийнэ.

³ Үнийн хязгаарлалттай захиалга бол уг үнэт цаасны нэгжийн үнэ, үнэт цаасыг худалдах зах зээлийн захиалга бол “Зах Зээлийн” гэсэн тэмдэглэгээ хийнэ.

_____ БРОКЕР, ДИЛЕРИЙН КОМПАНИЙН

ДИЛЕРИЙН ДААЛГАВАР⁴

20.. оны .. сарын ..-ний өдрийн арилжаанд

Захиалга өгсөн огноо, цаг минут	Худалдах, худалдах авахын аль нь болох	Үнэт цаасны нэр, төрөл /код/	Үнэт цаасны		Захиалгын төрөл, нөхцөл	Захиалгын биелэлт	
			Тоо, ширхэг	Нэг- жийн үнэ ⁵		Тоо, ширхэг	Нэгжийн үнэ

Захиалга нэгтгэсэн -----/гарын үсэг/

Захиалга хянасан-----/гарын үсэг/

⁴ Худалдах болон худалдан авах захиалгаар дилерийн даалгаврыг салган үйлдэж болно.

⁵ Үнийн хязгаарлалттай захиалга бол уг үнэт цаасны нэгжийн үнэ, үнэт цаасыг худалдах зах зээлийн захиалга бол “Зах Зээлийн” гэсэн тэмдэглэгээ, үнэт цаасыг худалдан авах зах зээлийн захиалга бол үнэт цаас худалдан авах мөнгөний дүнг бичнэ.